



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2020 оны 07 сарын 01 өдөр

Дугаар A/108

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.7.1 дэх заалт, Улсын Их Хурлын 2020 оны 45 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төсөлд Ховд аймагт хэрэгжүүлэхээр тусгуулах төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдийн саналыг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: Б.Баярсүх - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүдэд: Б.Ганболд- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Ч.Багдал - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Б.Даваадорж - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Н.Ганзориг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

С.Дорж - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Б.Батнасан - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Энхбаатар - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Л.Батгэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2.Таван жилийн үндсэн чиглэлд тусгах төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдийн саналыг сум, байгууллага, иргэд олон нийтээс авч “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, бусад Үндэсний болон аймгийн/ хөгжлийн баримт бичгүүдэд тусгагдсан зорилго, зорилттой нягт уялдуулан Үндэсний хөгжлийн газраас ирүүлсэн маягтын дагуу боловсруулж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2020 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсэг /Б.Баярсүх/-т даалгасугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД